



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/412

Номгон

Үндсэн хуулийн дугуйлан төсөл хэрэгжүүлж
ажиллах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойг угтан ард иргэдэд хууль тогтоомжийг энгийн, хялбараар таниулан сурталчлах, хүн бүр хуулийг ижил тэгш дагаж мөрддөг байх, хуулийн зөв хэрэглээг дадал болгох зорилготой "Үндсэн хуулийн дугуйлан" төслийг хэрэгжүүлсүгэй.

2. Төслийн Орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст үүрэг болгосугай.

3. Дээрх төслийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311063